



# **ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ ЭРХИЙН АСУУДАЛ**

---

ИЛТГЭГЧ С.ЭНХЦЭЦЭГ LL.M,MPA

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР

# АГУУЛГА

---

Энэхүү илтгэлээр гадаад улсын арбитраас гаргасан шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрч биелүүлэхэд тулгарч байгаа дараах асуудлыг хөндөнө:

- Нийтийн дэг журам;
- Ялгамжтай зохицуулалт /гадаад, дотоодын арбитрын шийдвэрийг гүйцэтгэх/.

Монгол Улсад арбитраар шийдвэрлэгдсэн маргааныг шүүхээс:

Хүлээн зөвшөөрч баталгаажуулах эсэх  
**(Recognition);**

Хэрэв хүлээн зөвшөөрсөн бол гүйцэтгэх  
**(Enforcement);**




# Монголын Олон Улсын Арбитрын шийдвэрийн биелэлтийг хангуулах



1

Сайн дураараа арбитрын шийдвэрийг биелүүлэх

2



3



# ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:

---

- (i) Арбитрын тухай хууль /48, 49/
- (ii) ИХШХШТХууль /184.1/
- (iii) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /5.1, 6.2.3/
- (iv) Олон улсын гэрээний тухай хууль,
- (v) 1994 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Олон улсын конвенцид нэгдэн орох тухай Монгол Улсын хууль /1958 оны "Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай" Нью-Йоркийн конвенц/
- (vi) 1961 оны Гаагын Апостилийн конвенц (2009)
- (vii) 1954 оны Гаагын Иргэний Хэргийн Конвенц
- (viii) УДШ-ийн тайлбарууд болно.

## **Арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл:**

/Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйл, “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай” конвенцийн 5 дугаар зүйл/

Конвенцийн 5 дугаар зүйлийн 2b заалтад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх орны **эрх бүхий байгууллага** тухайн шийдвэрийг биелүүлэх явдал нь тухайн орны **нийтийн дэг журамд** харшилж байвал;

Арбитрын тухай хуулийн 49.1.2.б заалтад Монгол Улсын **нийтлэг ашиг сонирхлыг** зөрчсөнийг **шүүх** тогтоосон бол...



**“НИЙТИЙН ДЭГ ЖУРАМ”, “НИЙТЛЭГ АШИГ СОНИРХОЛ”  
НЭР ТОМЪЁО “ORDRE PUBLIC” ГЭСЭН ФРАНЦ ҮГ  
/PUBLIC ORDER/PUBLIC POLICY/**

---

- **Хууль тогтоогч конвенцийн нэг ойлголтыг 2 өөрөөр томъёолсон;**
- **Тодорхойлолт байхгүй;**
- **Ямар тохиолдолд нийтийн дэг журамтай харшилсан гэж үзэх вэ гэдэг тодорхойгүй.**

## УЛС ОРНУУДЫН ШҮҮХ НИЙТИЙН ДЭГ ЖУРАМ ЗӨРЧСӨН ГЭЖ ҮЗЭХ ҮНДЭСЛЭЛ

АНУ	Арбитрын шийдвэрийг биелүүлэх улсын <b>ёс суртахуун, шударга ёсны</b> хамгийн энгийн ойлголтыг зөрчих тохиолдол
Австрали	<b>Ёс суртахуун, шударга ёсны</b> (justice) үндэс суурь, үндсэн асуудлыг хөндөж байгаа тохиолдол
Хонг Конг	Шийдвэр биелүүлэх улсын <b>шударга ёсны</b> ойлголтыг гутаан доромжилсон тохиолдол
Швейцарь	Хэрэв шийдвэр Швейцарьт зонхилох үзэл баримтлалын дагуу <b>эрх зүйн хэм хэмжээний</b> үндэслэл болбол зохих үндсэн бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн <b>үнэт зүйлсийг</b> үл хүндэтгэсэн бол
Франц	Францын <b>хууль эрх зүйн дэг журмыг зөрчсөн</b> , олон улсын шинж чанартай нөхцөл байдалд ч үл тэвчих <b>дүрэм журам, үнэт зүйлсийн цогцод харшилбал</b>
Герман	Хэрэв аливаа арбитрын шийдвэр <b>тогтсон хэм хэмжээг зөрчиж</b> , Германы төрийн болон эдийн засгийн суурь амьдралд нөлөөлөх буюу эсхүл Германы <b>шударга ёсны</b> тухай ойлголттой эвлэршгүй байдлаар харшилдаж байвал;



## УЛС ОРНУУДЫН ШҮҮХ НИЙТИЙН ДЭГ ЖУРАМ ЗӨРЧСӨН ГЭЖ ҮЗЭХ ҮНДЭСЛЭЛ

ОХУ	Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны болон ёс зүйн дүрэмд харшилсан; Иргэдийн амь нас, эрүүл мэнд, төрийн аюулгүй байдалд заналхийлсэн бол
Итали	Олон улсын тунхаглал болон конвенцид тусгалаа олдог хүний үндсэн эрхийг хамгаалах зорилготой, соёл иргэншлийн хувьд ижил улс үндэстэн бүрт хамааралтай түгээмэл зарчмуудад харшилсан бол
Англи, Уэльс	Шийдвэрийг биелүүлэх нь нийгмийн сайн сайханд илтэд хор учруулах, эсхүл төрийн эрх мэдлийг өмнөөс нь хэрэгжүүлдэг энгийн ухаалаг, бүрэн мэдээлэлтэй нийгмийн гишүүдийг бүхэлд нь гутаан доромжилсон болох тохиолдлууд орно.
Бразил	Үндэсний тусгаар тогтнолын ойлголтод харш
Энэтхэг	Энэтхэгийн эрх ашигт харшилж байвал
Европын холбоо	Европын холбоо нь Европын холбооны чиг үүргийн тухай хэлэлцээрийн 101 дүгээр зүйл заалттай харшилсан тохиолдол
Хятад	Өрсөлдөөний, Дампуурлын, Хүүгийн хувь хэмжээ, Валют арилжааны тухай зэрэг эрх зүйн императив хэм хэмжээнд харшилсан тохиолдлыг хамааруулж байна.

# ХУДАЛДААНЫ МАРГААН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ ШААРДЛАГА

---

Конвенцийн 1 дүгээр зүйлийн 3-т энэхүү конвенцид мэдэгдэл хийгч улс зөвхөн өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу худалдааны гэж тооцогдох гэрээний эсхүл гэрээний бус эрх зүйн бусад харилцаанаас үүсэх маргаанд энэхүү конвенцыг дагаж мөрдөхөө мэдэгдэж болохоор заасан.

Монгол Улс 1994 оны 5 дугаар сарын 26-ны өдөр УИХ-аас баталсан “Олон улсын конвенцид нэгдэн орох тухай” хуулийн 2 дугаар зүйлийн 2-т “Монгол Улс нь өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу гацхүү **худалдааны** гэж тооцогдох гэрээний болон эрх зүйн бусад харилцаанаас үүсэх маргаанд энэхүү конвенцийг хэрэглэнэ.” гэж заасан.

- Монгол Улс дотоодын хууль тогтоомжоор худалдааны гэж тооцогдох маргаан гэдгийг тодорхойлон хуульчлах шаардлагатай байна.

# ГАДААД, ДОТООДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА ЯЛГАМЖТАЙ ЗОХИЦУУЛАЛТ

---

Конвенцын 5 дугаар зүйлийн 1-д “Хариуцагч тал дараах нотлох баримтыг эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн тохиолдолд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзаж болно.” гэж заасан.

## Гэтэл

**ИХШХШТХ**уулийн 184 зүйлийн 3-т “... *арбитрын шийдвэр, ... биелүүлэх боломжийг нь шүүх хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн* дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна”

## ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙН ХУВЬД ДАРААХ БОЛОМЖ ХЯЗГААРЛАГДМАЛ:

---

- Хүсэлттэй танилцаж үндэслэлтэй хариу тайлбар өгөх;
- Үүрэг хүлээгч тал нотлох баримтаа бүрдүүлэх, нотариатаар баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт нотлох баримт гаргуулах;
- Шуудан харилцаа;
- Төлбөр, зардал ;
- Нотлох баримтыг үнэлэх /арбитрын шийдвэр, шийдвэрт гарын үсэг зурсан арбитрчдын гарын үсэг бодит эсэх, сонирхогч талаас гаргаж өгсөн хувь нь үнэн зөв эсэх/;
- Арбитрын тухай хуулийн 49.1.1, 49.1.2-т заасан шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах үндэслэлүүдийг тогтоох;
- Худалдааны маргаан эсэхийг тодорхойлох;
- Нийтийн дэг журамд харш эсэх.

# ДҮГНЭЛТ:

- **Нийтийн дэг журам** нь талуудын бие даасан байдлын зарчмаас дээгүүрт тавигдах тухайн улсын эрх зүйн императив хэм хэмжээ буюу эрх зүйн дэг журмын бүрэн бүтэн байдлаа хамгаалах боломжийг хууль тогтоогч болон шүүхэд олгодог илүү өргөн хүрээний арга хэрэгсэл байна. Иймд Монгол Улс “Public order” буюу “Нийтийн дэг журам” гэх ойлголтыг хууль тогтоомждоо тодорхойлж гадаадын арбитрын аливаа шийдвэрийг биелүүлэхэд хууль хэрэглээний болон эрх зүйн зохицуулалтын хувьд нэг мөр ойлгох, хэрэглэх шаардлагатай байна.
- Өнөөдөр гадаад улсын арбитрын бүх шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлж байгаа нь Нью Йоркийн конвенц болон хуулиар олгогдсон биелүүлэхээс татгалзах эрх, гарц, боломжоо ашиглаж чадахгүй байгаа төдийгүй Монгол Улсын эрх ашиг, үнэт зүйлд халдсан, шударга ёсны үнэлэмжийг алдагдуулсан шийдвэрийг биелүүлэх эрсдэлтэй байна.
- Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх үндэслэл байгаа эсэх, түүнийг биелүүлэх эсэхийг шүүх баталгаажуулахын тулд дотоодын арбитрын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанаас ялгаатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.
- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу “Худалдааны” гэж тодорхойлсноос бусад аливаа маргааныг шийдвэрлэсэн гадаад улсын арбитрын шийдвэрийг Монгол Улс /шүүх/ хүлээн зөвшөөрөх үүрэггүй юу гэдэг асуудал сонирхол татсан хэвээр байна.

---

**Анхаарал хандуулсанд  
баярлалаа.**